



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

Наадамчдын зам 1200, Арцатын ам, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 04 61, Факс: (976-11) 32 18 08
Цахим хуудас: www.uda.ub.gov.mn

2024.04.29 № 02/1158

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 28 дугаар хуралдааны тэмдэглэлээр “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний төслийг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан олон улсын байгууллагаас зөвлөгөө, зөвлөмж авч холбогдох мэргэжлийн болон төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаач, иргэд, олон нийтийн оролцоог ханган боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт даалгасан.

Улсын Их Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал”-ын 24-т “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг батлах тухай” тусгагдсан бөгөөд тус ажлыг яаралтай эцэслэн батлуулах шаардлагатай байгаа тул ажил гүйцэтгэх хугацааг сунгах боломжгүй болно.